

Мэдээлэл

## НОМХОН ДАЛАЙН ТӨРЛИЙН ИДЭВХИТЭЙ ЗАХАД ОРОГЕНЕЗ ХЭДИЙД ЭХЭЛЖ, ХЭДИЙД ДУУСДАГ ВЭ?

Ж.БЯМБА

МУИС. Газарзүй-геологийн факультет

Энэхүү мэдээлэлд бид зөвхөн далайн царцдастай структур эх газрын царцдастай болоход заавал дамждаг шилжилтийн царцдастай структур буюу орогенезийн тухай авч үзлээ. Гэхдээ шилжилтийн хөгжлийн үе шат хэзээ эхэлж хэдээ дуусдаг болохыг мэдэж байхад илүүдэх юмгүй. Мөн шилжилтийн хөгжлийн үед геотектоникийн ямар явц болдгийт бас мэдэж байвал зохино.

Далайн плитийн хэмжээнд үүсэж байгаа шилжилтийн бүс бол нэг бол далайн плитийн хэмжээнд хурдас хуримтлал нэмэгдэж плитийн хэмжээнд тасрал явагдсанаас (автохтон замаар), эсвэл далай дээр байгаа уул, арал, оргогдэл зэрэг эсрэг элементүүдийг ашиглан сүбдүкц явагдвал (автохтон) тус тус үүснэ. Ингэж сүбдүкцийн явц эхлэж шургасан плит Беньофын бүсэнд хүрэн ондор темпратурт ортон Si, Al, Na, K, Mn, Mg, Ca зэрэг том диаметртэй, хөнгөн ионтой голдуу литофилийн элементүүд дээш шилжих замдаа хэсэгчилсэн хайлалтыг дагуулан улмаар гадаргад бялхахаас гадна, зарим хэсэг нь гүнд талсжиж интрузивийг хэлбэржүүлнэ.

Энэ үеэс л орогенезийн хөгжил эхэлсэн гэж үзэж болно. Эхний түрэлтийн энэ магм бол натри нь калигаас давамгайлсан найрлагатай толейтын эгнээний вулканит ба интрузивийг үүсгэнэ.

Энэ сүбдүкцийн явцын дараа дараагийн магмын түрэлт бол голдуу царцдаасаар бохирдон калигаар баяжсан байх учир андезит гранодиорит, гранит зэрэг андезитийн эгиээний магматизм зонхилсон байна. Энэ үеэс л коллизын хөгжил эхэлнэ. Тэгэхээр коллиз бол орогенезийн хөгжлийн нэгэн хэсэг юм. Коллизын явцад бүрэн тогтвржкоогүй (хагас тогтвржисон) эх газар үүснэ. Өөрөөр хэлбэл гранит-метаморф үе үүснэ.

Харин энэ хагас тогтвржисон эх газар нь коллизын дараахи оргөгдлийг дамжин хожуу орогенезийн шүлтглэг ба шүлтлэгдүү гранитоид түрснээр бүрэн тогтвржисон эх газар өөрөөр хэлбэл эх газрын царцдаас хэлбэржиж дууссан гэсэн үг.

Шилжилтийн царцдастай структурний хэмжээнд доорхи геологийн явцууд болдог:

1. 10 орчим км тунамал-вулканоген хурдас хуримталаа.
2. Шохойлог(кальцлаг)-шүлтлэг тасралтгүй ялгарсан найрлагатай вулканит бялхана.
3. Мөн тийм найрлагатай гранитоид түрнэ.
4. Гол атираажилт болно.
5. Бүсийн метаморфизм явагдана.
6. Калийн анхны метасоматоз болно.
7. Царцдаас зузаарч 10-15 км хүрнэ.

8. Уул үүсэж ихээхэн хэрчигдсэн гадаргатай рельеф буй болно.

Энэ бүгдээс дүгнэлт хийж үзвэл орогенез бол сүбдүкцээс эхлээд хожуу ороген хүртэл явагддаг нь харагдаж байна. Эх газрын царцdas үүсэх явц бол сүбдүкцийн явцаас арай хожуу коллизоор кали гранитоид түрснээр эхлээд орогенезтэй хамт дуусдаг гэж үзэж болно.

**Дүгнэлт.**

1. Орогенез бол шилжилтийн хугацааг нийтэд нь хамардаг байна.
2. Гранит-метаморф үе үүсэх явц нь калийн гранитоид түрснээр (коллизоор) эхлэх бөгөөд эх газрын царцdas хэлбэржилтийн эхлэл нь болдог байна.
3. Орогенезийн явцад геологийн олон үйл явдал болдог нь далайн төрлийн царцdas эх газрын төрлийн царцdas болж хувирах шилжилтийн гол хүчин зүйл болно.